

2013 04 11

Д.д.д. 33

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын "Агаарын тухай" хуулийн 8.1.1, 8.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Арвайхээр хотын Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж агаарын бохирдол бууруулах ажилд бодитой ахиц гаргаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Г.Баясгалан/, Арвайхээр сумын Засаг дарга /А.Ишдорж/-д нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБОЛД

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн
33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт.

АРВАЙХЭЭР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НЭГ.Газар зүйн байршил, бичил уур амьсгал.

Өвөрхангай аймаг 1931 онд байгуулагдсан. Монгол улсын төв хэсэгт байрладаг, аймгийн төв Арвайхээр хот нь Монгол улсын төв цэг Өвөрхөшөөтөөс 130 км, эртний нийслэл Хархориноос 135 км, Улаан цутгалангаас 170, өөрийн бүсийн аймгууд болох Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотоос 208 км, Архангай аймгийн төв Цэцэрлэг хотоос 255 км, Булган аймгийн төв Булган хотоос 364 км, Орхон аймгийн төв Өрдэнэт хотоос 635 км, Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос 634 км зайд тус тус оршдог бөгөөд аймаг нь нийт 62.9 мянган км² нутаг дэвсгэртэй. Тус аймгийн нутаг дэвсгэр эх газрын эрс тэс, хуурайвтар уур амьсгалтай бүсэд хамаарагдана.

Цаг уурын ажиглалтын олон жилийн дундажаас харвал жилийн дундаж температур, хангайн сумуудад 0-4 градус, хээрийн бүс нутагт 0-2 градус, говийн сумдад + 2-4 градус байдаг. Жилийн хамгийн хүйтэн сар нь аль ч нутагтаа 1 дүгээр сар байх бөгөөд температурын хувьд нилээд тогтвортой өндөрлөг уулаар хүрээлэгдсэн Орхон, Онги голын хөндий нутгаар -18-аас -20 хэм байхад бусад нутгаар -15-аас -18 хэм хүрдэг байна. Зарим өвөл Орхон гол, түүний цутгалаг голын сав нутгаар -40-өөс -43 хэм бусад тал хээр, говийн нутгаар -35-аас -39 хэм хүрч хүйтэрдэг.

Тус аймаг нь улсын нутаг дэвсгэрийн 4 хувь, хүн амын 4.5 хувийг, эзлэж, аймгийн суурин хүн амын тоо жилийн эцсийн байдлаар 110541 болж өмнөх оныхоос буурч, төв суурин газарт оршин суух хүн 1.4 хувь буюу 1537 хүнээр өссөн байна.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сум нь 28722 гаруй хүн амтай аймгийн нийт хүн амын 23,1 хувь нь Арвайхээрт оршин сууж байна. 2013 оны 1-р сарын байдлаар тус сум 8284 өрх байгаагаас 551 өрх орон сууцанд, 4121 өрх тохилог тусдаа байшинд, 195 өрх нийтийн байранд, 39 өрх тохилог тусдаа орон сууцанд 3208 өрх гэрт амьдарч үйлдвэрлэл үйлчилгээ хөгжиж байгаа голлох бүс нутаг болж байна.

1.2 Агаарын чанарын өнөөгийн төлөв байдал

Агаар нь хүн болон аливаа амьд биетийн амьдралын зайлшгүй хэрэгцээ бөгөөд түүнийг өөр зүйлээр орлуулах ямар ч боломжгүй билээ. Дэлхийн хүн ам олширч үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжсөнөөс янз бүрийн бохирдуулах бодис агаарт их хэмжээгээр гаргах болсон нь агаарын цэвэр, ариун чанарыг алдагдуулж байгаа төдийгүй озоны давхаргыг гэмтээх зэрэг агаарын бүтцийг эвдэх аюул учруулахад хүрч байна.

Агаар нь амьсгалын замаар хүний бие, эрүүл мэндэд шууд нөлөөлөхийн хамт цацраг идэвхжил, химийн хорт бодисыг богино хугцаанд их хэмжээний газар тараах орчин болдог.

Хөгжлөө дагаад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихэссэнээр орчны бохирдлын асуудал ялангуяа агаарын бохирдол Арвайхээр сумын тулгамдсан асуудлын нэг болоод байна. Үүний тодорхой жишээ нь өвлийн улиралд баруун хойноосоо өмнөд хэсгээ дамнасан утаан хөшгөөр бүрхэгдэн, үзэгдэх орчин муудаж амьсгалахад хүндрэлтэй болж улмаар сумын нийт иргэдийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлөх хэмжээнд хүрээд байна.

Өвөрхангай аймгийн УЦУОШАлбаны АШЛаборатори нь Арвайхээр суманд агаар орчны бохирдлыг хянах суурин 2 харуултай. Энэ харуул нь гадаад орчны түгээмэл бохирдуулагчид болох агаар дахь

- SO₂ /хүхэрлэг хий/
- NO₂ /азотын давхар исэл/
- CO /нүүрстөрөгчийн дутуу исэл/
- Тоос зэрэг агаар орчны шинжилгээний байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сум нь барилгын уур амьсгалын 2-р бүсэд багтдаг. Барилга байгууламжууд нь дулаан хангамжийн сүлжээндээ жилд 15000 гаруй тн нүүрсийг хэрэглэж байна. Дулааны эх үүсвэрт барилга байгууламжуудыг халаах зориулалттай дунд хүчин чадлын гар ажиллагаатай болон албадмал эргэлттэй 70 гаруй зуухнуудыг ашиглаж, 11824 Гкал/жил үйлдвэрлэл явуулж байна. Дээрхи зуухнууд нь "MNS 5043-2001" стандартын шаардлага хангахгүй, түлшний зарцуулалт ихтэй, ашигт үйлийн коэффициент багатай, механикжилт муутай, ашиглалтын зардал өндөр байна.

Арвайхээр хотын одоо хэрэглэж байгаа 28000 тн гаруй нүүрснээс байгаль орчинд хаягдаж байгаа дутуу шатсан хэсэг болон үнсний хэмжээ нь 672 тн/жил, хүхрийн исэл 3350 тн/жил, нүүстөрөгчийн исэл 279,07 тн/жил, азотын исэл 35,91 тн/жил, нүүрс

хүчлийн хий буюу хүлэмжийн хийн гаралт 15840 тн/жил байгаа нь байгаль орчныг бохирдуулж байгаа гол хүчин зүйл болж байна.

Суурин эх үүсвэрээс ялгарах хорт бодисын агууламжийг JICA- олон улсын байгууллагын судалгааны аргачлалаар тооцоолоход агаарын бохирдлын 60% нь гэр хорооллоос, 40% нь уурын зуухнуудаас ялгарч байна.

Сүүлийн жилүүдэд ажиглалт, судалгаанаас үзэхэд Арвайхээрт хүхэрлэг хийн агууламж, 0,130 мг/м³ азотын давхар исэл болон нүүрстөрөгчийн дутуу исэл 0,176 мг/м³, тоос 0,208 мг/м³ болж 10,11,1 дүгээр саруудад хүлцэх агууламжаас давах хандлага ажиглагдсан байна. 2013 оны байдлаар авто техникийн улсын үзлэгээр аймгийн хэмжээнд 9129 машин тоологдсоны 3181 нь Арвайхээрт байгаагийн 2672 нь 10-аас дээш жил эдлэгдсэн хуучин машин, өөрөө явагч хэрэгсэл, 313 мотоцикл тоологдсон байна.

Аймгийн хэмжээнд 70 гаруй нам даралтын дулааны зуух байгаа бөгөөд түүний 0,6 га талбайтай үнсэн саң, 10 багийн гэр хорооллын 7329 өрхийн ердийн галлагаатай зуух, түүнчлэн газрын эвдрэл, үйлдвэрлэлийн явц, үйл ажиллагаанаас үүссэн шороо тоос 46,6 га талбай бүхий хогийн цэг, 155 га хогоор бүрхэгдсэн талбайнууд хотын агаарын бохирдлыг нэмэгдүүлэх гол эх үүсвэр болж байна.

Судалгаанаас үзвэл уурын зуухнуудаас 1014-39.0 мянган тонн, тээврийн хэрэгслээс 9.0 орчим мянган тонн, гэр хорооллоос 1234- 59.0 мянган тонн агаар бохирдуулах бодис жил бүр агаарт хаягдаж байна. Сүүлийн жилүүдэд агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжээ жилээс жилд тодорхой хэмжээгээр нэмэгдсээр байгаа бөгөөд 10-3-р саруудад хүхэрлэг хийн хэмжээ бусад сарынхаас их байна. Хүхэрлэг хий нь хүхэр агуулсан нүүрс түлснээс үүсдэг ба гол эх үүсвэр нь манай аймгийн хувьд олон жижиг уурын зуухнууд, гэр хороолол байдаг учир галлагаа зогссон зуны улиралд буурч, өвлийн улиралд өсч байгаа нь харагдаж байна.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгаран гарч буй утаа нь хүний амьсгалах түвшинд ойр зайд буюу 0,2 м өндөрт цацагддаг бөгөөд түүний найрлагад хүний амьсгалын замын цочмог болон архаг өвчин, харшлын эмгэг үүсгэх, элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн системийн эрхтний үйл ажиллагааг алдагдуулах, амьсгал боох, хорт хавдар үүсгэх үйлчилгээтэй нүүрстөрөгчийн исэл, азотын исэл, нүүрстөрөгч, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, бензпирен, альдегид зэрэг 200 гаруй төрлийн хорт бодис байдаг байна.

Хийн мандлын агаарыг бохирдуулагч бодисууд нь хүний бие махбодийн дархлын урвалыг өөрчилж, гадны эмгэг төрүүлэгч нянгуудыг эсэргүүцэх чадварыг сулруулж улмаар хүн амын өвчлөл, ялангуяа харшил үүсэх нөхцөл бүрдүүлдэг.

Ялангуяа өвлийн улиралд салхины хурд бага байдаг учир төвлөрсөн газрын дээр агаарын температурын эсрэг агаарт утаа тортог, элдэв хорт хийн хольцууд нэмэгдэх нэгэн нөхцөл болдог байна.

Баруун хойноосоо өмнөд хэсгээ дамнасан утаан хөшгөөр бүрхэгдэн, үзэгдэх орчин муудаж амьсгалахад хүндрэлтэй болсон. Сүүлийн арваад жилийн судалгаанаас үзэхэд Арвайхээрийн хүн амын амьсгалын замын өвчлөл аймгийн дунджаас дээгүүр гарсан үзүүлэлттэй байна.

ХОЁР. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, бодит шаардлага.

Агаарыг бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагыг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

а/ Хөгжил нь агаар, ус, хөрс, биологийн орчинд хохирол учруулах, түүнийг эвдэх, устгахад чиглэсэн байх ёсгүй гэсэн тогтвортой хөгжлийн гол зарчмыг хэрэгжүүлэх;

б/ Агаар дахь байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөллөөс үүсэх агаарын бохирдлын улмаас агаарын чанарт өөрчлөлт орох магадлалтайг харгалзан түүнээс сэргийлэх арга хэмжээ авах;

в/ Цэвэр агаар нь амьдралын эх булаг, аливаа амьд биетийн оршин тогтнох зайлшгүй нөхцөл бөгөөд дэлхийн бөмбөрцгийн дулааныг гадагш алдахгүй, нарны хорт туяа, солирын мөргөлтөөс хамгаалж байдаг тул түүнийг цэвэр, ариун байлгах нь улс, үнэдстэн, иргэн бүрийн үүрэг мөнийг ухамсарлан, түүнийг хамгаалах талаар бодитой ажил хийх;

г/ Азотын давхар ислийн сарын дундаж агууламж $0.015-0.037 \text{ мг/м}^3$, хамгийн их нь 0.176 мг/м^3 -д хүрч АЧС болох $0,085 \text{ мг/м}^3$ - хэмжээнээс давсан тохиолдол 4-5 удаа ажиглагдаж өмнөх оны дундажаас 3-8%, хамгийн ихээс 40%-иар ихэссэн, тросжилтын сарын дундаж агууламж нь $0,092-0.208 \text{ мг/м}^3$ байгаа нь АЧС-аас 2-5 дахин давсан бохирдолтой байгаа:

д/ Өвөрхангай аймгийн хэмжээнд 21 сумын нийтдээ том жижиг оврын 126 зуух тоологдсоны 70 уурын зуух нь Арвайхээр суманд жилдээ 28.000 тонн түүхий нүүрс, айл өрхүүд жилд дунджаар 5,3 тонн нүүрс хэрэглэж агаарын бохирдлын 70 гаруй хувийг эзлэж байгаа:

е/ Өвөрхангай аймгийн нийт хүн амын 25 гаруй хувь нь амьдардаг Арвайхээр хотын агаарын бохирдол сүүлийн жилүүдэд нэмэгдэж өвлийн улиралд тогтмол утаан хөшиг тогтож, улмаар амьсгалын замаар хүний бие, эрүүл мэндэд шууд нөлөөлж байгаа нь тогтоогдсон зэрэг шалтгаан нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болж байна.

ГУРАВ.Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

3.1.Хөтөлбөрийн зорилго

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж агаар, орчныг аливаа бохирдлоос хамгаалах бодлого, үйл ажиллагаа явуулж, Арвайхээр хотын агаарын бохирдлыг одоогийн байгаа түвшингээс бууруулах арга хэмжээг цогцоор нь шийдвэрлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

3.2.Хөтөлбөрийн үндсэн зорилт

Хөтөлбөрийн үндсэн зорилтыг дараахь байдлаар тодорхойлж байна:

1. Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, менежментийн зохистой тогтолцоог бий болгох;

2. Агаарын чанарын хяналт, шинжилгээний ажлын техник хэрэгсэл, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;

3. Агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авч гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, төвлөрсөн системд холбох, утаагүй зуухаар хангах, иргэд олон нийтийн оролцоог хангах эдийн засгийн хөшүүрэг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ.

ДӨРӨВ. Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1 . Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, менежментийн зохистой тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга зүйн зөвлөлгөө өгөх, салбар дундын зохицуулалт хийх,хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн уяалдааг хангах " Агаарын бохирдол бууруулах аймгийн зөвлөл"-ийг байгуулах.

4.1.2 "Бохирдуулагч нь төлөх, Ашиглагч нь хамгаалах" зарчмыг хэрэгжүүлэх журам боловсруулж хэрэгжүүлэх.

4.1.3 Агаарын бохирдол, найрлага бүтцийн талаар тогтмол судалгаа шинжилгээ хийж, нийтэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх.

4.1.4 Агаарыг хамгаалахтай холбогдсон хууль, тогтоомжийг боловсронгуй болгоход орон нутгийн онцлого, өнөөгийн нөхцөл байдал зэргийг харгалзан санал боловсруулж хүргүүлэх, захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавин хариуцлага тооцдог механизм, тогтолцоог бүрдүүлэх.

4.1.5 Агаарыг бохирдуулагч эх үүсвэрт тавих иргэдийн болон бүх нийтийн хяналтыг төрийн хяналттай хослуулан зөрчлийг газар авахуулалгүй зогсоох арга хэмжээ авч хэвшүүлэх.

4.2. Агаарын чанарын хяналт, шинжилгээний ажлын техник хэрэгсэл, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.2.1 Агаарын чанарын хяналт-шинжилгээний цэг сүлжээг өргөтгөж, мэргэжлийн байгууллага, ажилтнуудыг техник хэрэгслээр бүрэн хангах;

4.2.2 Тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт бусад эх үүсвэр болон нефть-химийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх цэг, дулааны зуухнуудад экологийн магадлан оношилгоо хийх зөөврийн багжтай болгох ажлыг зохион байгуулах;

4.2.3 Агаарын чанарын хяналт-шинжилгээний мэргэжлийн боловсон, хүчин, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтан бэлтгэх, давтан сургах ажлыг техник, технологийн шинэчлэлтэй уялдуулан чиглэсэн зорилготой хэрэгжүүлэх.

4.3 Агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авч гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, төвлөрсөн системд холбох, утаагүй зуухаар хангах, иргэд олон нийтийн оролцоог хангах эдийн засгийн хөшүүрэг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.3.1 Бохирдлын зэрэглэл, бүсчлэлийг тогтоож, зурагт буулган бүсчлэл бүрт тохирсон арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлэх.

4.3.2 Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, үе шатны ажлын төлөвлөгөө гаргах.

4.3.3 Гэр хорооллын айл өрхийн зуух-яндан-түлшний бүтэц, шаталтын технологийг өөрчлөн сайжруулах, зохистой хувилбарыг сонгон шалгаруулж, айл өрхүүдийг бүрэн шаталттай, сайжруулсан зуухаар шат дараатай хангах.

4.3.4 Аж ахуйн нэгж, байгууллагуудын нам даралтын зууханд технологийн шинэчлэл хийх, гэр, орон сууцны дулаалгыг сайжруулах замаар түүхий нүүрсний хэрэглээг багасгаж, утаа, тортогны ялгаралтыг 50 хүртэл хувь бууруулах.

4.3.5. Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хязгаарлаж, гэр хорооллын өрхүүдийг боловсруулсан, утаа багатай түлшээр хангах, утаа багатай түлшний үйлдвэрлэлийг дэмжих, хэрэглээг нэмэгдүүлэх.

4.3.6 Гэр хорооллыг орон сууцжуулах, гэр хорооллын айл өрхийг хэсэгчлэн төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

4.3.7 Боловсруулсан түлшийг айл өрхөд түгээх бөөний болон жижиглэн худалдааны сүлжээг бий болгон хөгжүүлэх.

4.3.8 Агаар бохирдуулагч эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын янданг стандартын шаардлагад нийцсэн шүүлтүүртэй болгох.

4.3.9 Цахилгаан болон сэргээгдэх эрчим хүч ашиглах халаалтын техник тоног төхөөрөмжийг нэвтрүүлсэн, утаагүй түлш үйлдвэрлэн зах зээлд борлуулсан, шинэ техник, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг урамшуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх.

4.3.10. Дулааны цахилгаан станцыг барьж, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгдсэн дулаанд холбох ажлуудыг эхлүүлэх.

4.3.11. Тээврийн хэрэгсэл болон ахуй хэрэглээнд хийн түлш нэвтрүүлэх нөхцлийг судлан аймагт хийн түлш цэнэглэдэг станц, сумдад зөөвөрлөх тусгай зориулалтын авто машин авч үйл ажиллагааг эхлүүлэх.

4.3.12. Зөвшөөрөгдөх хэмжээнээс их утаа их гаргадаг авто машиныг Замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хяналтыг тогтмолжуулах.

4.3.13. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх бүх нийтийн хөдөлгөөн, аян өрнүүлэх замаар ногоон байгууламжийг жил бүр 4 га талбайгаар нэмэгдүүлэх.

4.3.14. Хөрсний усаар ногоон байгууламж услах болон явган хүний зам, талбайг чийгшүүлэх тогтолцоог бий болгох;

4.3.15. Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн түүхий нүүрсийг боловсруулах, угаах үйлдвэрлэл бий болгох техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх.

4.3.16. Хямд өртөгтэй нийтийн орон сууц барих санал санаачлагыг Газар олголт, инженерийн дэд бүтэцээр дэмжиж, үе шаттайгаар хэрэгжүүлэх.

ТАВ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг дараах 2 үе шатаар хэрэгжүүлнэ.

5.1 Нэгдүгээр үе шат 2013-2015 он

5.2 Хоёрдугаар үе шат 2016-2018 он

ЗУРГАА. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллаж, аймгийн Засаг даргын Тамгийн газар бодлого чиглэлээр хангаж, сумдын ЗДТГазар, БОАЖГазар, дүүргийн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд хэрэгжүүлнэ.

ДОЛОО. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр

Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

7.1 Агаарыг хамгаалах, хяналт-шинжилгээний арга хэмжээнд зориулан улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, хөгжлийн сангуудаас гаргах хөрөнгө:

7.2 Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах хөрөнгө:

7.3 "Цэвэр агаар сан" –гаас гаргах хөрөнгө:

7.4 Бохирдуулагч нь төлөх зарчимаар төвлөрүүлсэн хөрөнгө:

7.5 Гадаад дотоодын төсөл хөтөлбөр, тусламжийн хөрөнгө:

НАЙМ. Хүрэх үр дүн

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд төр, засгаас явуулж буй бодлогыг хэрэгжүүлж, амьд байгалийн тулгуур орчин болсон хий мандлын агаарыг цэвэр, байлгаж, одоогийн үүсээд байгаа бохирдлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй агаар орчинд амьдрах нөхцөл бүрдүүлж, дараахь үр дүнд хүрнэ: Үүнд

8.1 Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг зохицуулах орчин, нөхцөл бүрдэж, нэгдсэн удирдлага, цогц бодлого тодорхойлогдож зөв менежмент бий болно.

8.2 Агаарын бохирдлыг хянах нэгдсэн сүлжээ бий болж, бохирдлын түвшинг бүсчлэл бүрт тогтоон авах арга хэмжээг оновчтой төлөвлөх нөхцлийг бүрдүүлж, орчин үеийн шаардлага хангасан хяналтын бааз бий болж агаар дахь бохирдуулагч хэмжих үзүүлэлтийг 4-өөр нэмэгдүүлсэн байна.

8.3 Нүүрсний чанарт ахиц гаргаж, техник, технологийн шинэчлэлт хийх, түлшний чанарыг сайжруулах утааг шүүх, цэвэрлэх шинэ технологи нэвтрүүлэх замаар агаар дахь бохирдуулагч бодисын хэмжээг одоогийнхоос 1.8 дахин бууруулсан байна.

8.4 Тээврийн хэрэгслийг утааны бохирдолд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож шингэн болон дэвшилтэт шинэ төрлийн түлш хэрэглэх ажлыг өргөжүүлэх замаар хөдөлгөөнт эх үүсвэрийн агаарт гаргах бохирдлын хэмжээг бууруулсан байна.

8.5 Дулааны цахилгаан станц барих ажлыг эхлүүлэн, хөтөлбөрийн 1-р үе шатанд гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах үндэслэл тооцоог боловсруулан, гэр хорооллыг орон сууцжуулах, гэр хорооллын айл өрхийг хэсэгчлэн төвлөрсөн дундан хангамжид холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан зуухаар ердийн галлагаатай 7329 өрхийг бүрэн хангаж гэр хорооллоос гарах бохирдлыг 2012 оны түвшингээс 2 дахин бууруулна.

8.6. Аймгийн төвлөрсөн суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 20 хүртэл га талбайгаар нэмэгдсэн байна.

8.7 Гэр хорооллын дэд бүтэц сайжирч, хямд өртөг бүхий нийтийн орон сууцны тоо нэмэгдсэн байна.

___оОо___